

Хотын Ариун цэврийг хянан харгалзах газар

1925-12-11-нд Засгийн газрын 44-р хурлаар Хотын захиргааг жинхэнэ болгож, дүрмийг улсын бага хурлын тэргүүлэгчдэд явуулан батлуулахаар тогтоожээ. 1925-12-11-нд Улсын 2 дугаар Их хурлаар хотын захиргааны дүрэм дөчин есөн зүйлийг баталсан байна.

Хотын захиргааны гүйцэтгэх газар нь долоон тэргүүлэгчидтэй, түүний дарга, орлогч, нарийн бичгийн дарга нар нь товчоо болон бүрэлдэж байсан бөгөөд хэлтсүүд нь Ерөнхий хэлтэс, Ардыг гэгээрүүлэх хэлтэс, Ардын эрүүлийг сахих хэлтэс, Аж үйлдвэрийн хэлтэс /энэхүү хэлтэст санхүү, аж ахуй, тоо бүртгэх салбарууд хамаарагдаж байв/-тэй байхаар заажээ. Хэлтсүүд нь тухайн үеийн байдлаас өөрчлөгдөж байжээ. Албан газар, цэрэг, үйлдвэрийн хэлтсүүдтэй болсон байна.

1925 онд хотын захиргаа нь 6 хэлтэс, 104 орон тоотой байв.

Улсын 2 дугаар их хурлын шийдвэр болон Засгийн газрын 22 дугаар хурлын 7-р зүйлийг үндэслэн 1926-9-3-нд Засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927-1-1-нээс эхлэн хотын захиргааны газрыг Дотоод яамны харьяанаас өөрчилж тусгай эрхтэй биеэ даасан газар болгохоор заажээ.

1926 оны 9 дүгээр сарын 3-нд Ардын засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хотын захиргааг Дотоод яамны харьяанаас өөрчилж, тусгай эрхтэй, биеэ даасан газар болгохоор тогтоожээ.

1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан

1931-9-21-нд УБХ-ын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлын тогтоолоор Улаанбаатар аймгийн захиргааг гишүүд 11, орлогчдыг 5 хүнээр аймгийн захиргааны байгуулалтыг тэргүүлэгч, орлогч, нарийн бичгийн дарга, ерөнхий хэлтэс, цэргийн хэлтэс, хөдөө аж ахуйн хэлтэс, санхүүгийн хэлтэс, хотын нийтийн аж ахуйг эрхлэх хэлтэс, ардыг гэгээрүүлэх явдлын хэлтэс, Цагдан сэргийлэх явдлын хэлтэс, Улсын хянан байцаах бүртгэлийг Эрхлэх товчоо зэрэг зохион байгуулалтаар тогтоожээ.

1932 оны 10 сард Улаанбаатар хотын захиргааг Төв аймагтай нэгтгэж Улаанбаатар аймгийн Захиргаа болгосон.

1933 оны 12 дугаар сарын 29-нд Сайд нарын Зөвлөлийн 42 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл ээр 1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан бөгөөд бүтцийг нь:

Хотын ариун цэврийн хянан харгалзах газар

1937 оны 2 дугаар сарын 13-нд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн “Нийслэл Улаанбаатар хотыг захирах яам” болгохоор тогтоосон байна.

1960-4-11 нд Сайд нарын Зөвлөл, НамынТөв Хорооны 170/111-р тогтоолоор Улаанбаатар хотын эрүүлийг хамгаалах хэлтсийг газар болгон өргөтгөж, төв газрууд, эмэгтэйчүүдийн тасаг, /консультандын хамт/ халдварт өвчнийг эмчлэх больниц, хотын халдварт өвчнийг эсэргүүцэх ариунцэврийн станцыг Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд харьяалуулжээ.